

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хяналт шалгалт, үнэлгээний газар



Хяналт шалгалтын ажлын сарын мэдээ

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН САРЫН МЭДЭЭ

(2021 оны 8-10 дугаар сар)

Улаанбаатар хот
2021 он

2021 оны 8-10 дугаар сард Улсын Их Хурлын тогтоолоор тодорхой асуудлыг шалган судалж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий дараах түр хороод үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн ажиллав.

Хүснэгт 1. Улсын Их Хурлын тогтоолоор байгуулагдсан түр хороо

Д/д	Түр хороо байгуулсан тогтоол	Түр хорооны бүрэлдэхүүн
1.	2020.10.29 №31 Түр хороог байгуулж, бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай УИХ-ын тогтоол /КОВИД-19/	Түр хорооны дарга: УИХ-ын гишүүн Б.Баттөмөр Түр хорооны гишүүд: УИХ-ын гишүүн Х.Болорчулуун - БОХХААБХ/, Ж.Мөнхбат - БСШУСБХ, Б.Бат-Эрдэнэ - ЁЗСХБХ, Н.Учрал - ИЦББХ, М.Оюунчимэг - НББХ, Л.Энх-Амгалан - ТББХ, Б.Жавхлан - ТБХ, Б.Чойжилсүрэн - ҮББХ, С.Бямбацогт - ХЗБХ, Ж.Ганбаатар - ЭЗБХ-ны дарга нар болон Б.Бейсен - УИХ дахь АН-ын төлөөлөл, С.Ганбаатар - УИХ дахь "Та бидний эвсэл"-ийн төлөөлөл, Т.Доржханд - УИХ дахь "Зөв хүн электорат эвсэл"-ийн төлөөлөл, Н.Алтанхуяг - Бие даагч ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Зөвлөх С.Эрдэнэчимэг, референт Ц.Рэнцэнтогтох, Х.Хэрлэн
2.	2021.03.26 №30 Түр хороог байгуулах тухай УИХ-ын тогтоол /Оюу Толгой/	Түр хорооны дарга: УИХ-ын гишүүн Ц.Даваасүрэн Түр хорооны гишүүд: УИХ-ын гишүүн Ш.Адъяаа, Н.Алтанхуяг, П.Анужин, Ё.Баатарбилэг, Б.Бат-Эрдэнэ, Ж.Бат-Эрдэнэ, Х.Болорчулуун, С.Бямбацогт, Ж.Ганбаатар, С.Ганбаатар, Г.Ганболд, Н.Ганибал, Х.Ганхуяг, Г.Дамдинням, Б.Дэлгэрсайхан, Б.Жаргалмаа, Ж.Мөнхбат, Ц.Сандаг-Очир, Ж.Сүхбаатар, Г.Тэмүүлэн, Ч.Ундрам, С.Чинзориг, Б.Энхбаяр ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Зөвлөх М.Солонго, референт Д.Гэрэлт-Од

Монгол Улсын Их Хурлын тухай
хуулийн 39 дүгээр зүйлийн
39.1.4 дэх заалт

Улсын Их Хурлын 2020 оны 31 дүгээр тогтоолоор байгуулагдсан Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн биелэлтийг сар тутам нээлттэйгээр хэлэлцэж, хяналт тавих, шаардлагатай бол УИХ-ын холбогдох Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий түр хороо 8-10 дугаар сард дараах асуудлуудыг хэлэлцэв.

2021.09.13-ны өдрийн хуралдаанаар:

- Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед Нийслэлийн онцгой комиссоос хэрэгжүүлж байгаа ажлууд, цаашид авах арга хэмжээний талаарх танилцуулгыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Нийслэлийн онцгой комиссын дарга Д.Сумъяабазар;
- Нийслэл дэх цар тахлын дэгдэлтийн нөхцөл байдал, эмчилгээ, үйлчилгээний хангамж хүртээмж, Нийслэлийн Эрүүл мэндийн газраас хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх танилцуулгыг Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга Б.Бямбадорж;
- Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн шинэ жил эхэлсэнтэй холбогдуулан Нийслэлийн боловсролын байгууллагаас Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын эсрэг авч байгаа арга хэмжээ, цаг үеийн нөхцөл байдал, хичээл сургалтыг хэвийн явуулахад чиглэсэн төлөвлөлтийн талаарх танилцуулгыг Нийслэлийн Боловсролын газрын дарга Ж.Гантулга нар тус тус хийсэн. Мэдээлэл, танилцуулга сонссонтой холбогдуулан 2021.09.14-ний өдрийн УИХ16/8077 албан тоотой Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Нийслэлийн онцгой комиссын дарга Д.Сумъяабазарт чиглэл өгсөн.





Улсын Их Хурлын 2021 оны 30 дугаар тогтоолоор байгуулагдсан “Оюу толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай” Монгол Улсын Их Хурлын 2019 оны 92 дугаар тогтоолын хэрэгжилтэд хяналт тавих, шаардлагатай бол санал боловсруулж, дүнг нэгдсэн хуралдаанд танилцуулах үүрэг бүхий Түр хороо 8-10 дугаар сард дараах асуудлуудыг хэлэлцэв.

- 2021.08.31-ний өдөр тус түр хорооны 2021 оны 1 дүгээр тогтоолоор байгуулагдсан ажлын хэсэг Оюу Толгой төслийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцах ажлын хүрээнд хийх ажлын төлөвлөгөөг баталсан.
- 2021.09.07-ны өдөр “Оюу Толгой” ХХК болон холбогдох төрийн байгууллагуудын төлөөлөлтэй уулзаж, Оюу Толгой төслийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа усны талаар мэдээлэл сонсож, санал солилцсон.
- 2021.09.08-ны өдөр Рио Тинто Зэсийн группийн захирал Б.Болд, Туркойз Хилл Ресурс компанийн захирал Стийв Тибоу нараас Монгол Улсын Ерөнхий сайдад ирүүлсэн захидал, санхүүгийн болон хуулийн зөвлөх компаниудыг сонгон шалгаруулах тухай, Түр хорооны 2021 оны 7 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны 03 тоот тэмдэглэлээр Засгийн газарт хүргүүлсэн чиглэлийн дагуу авч хэрэгжүүлсэн ажлын талаарх мэдээллийг сонссон. Мэдээлэлтэй холбогдуулан Засгийн газарт хуралдааны 04 дүгээр тэмдэглэлээр үүрэг өгсөн.
- 2021.09.24-ний өдрийн дэд ажлын хэсгийн хуралдаанаар БОЖЯ болон Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газраас Оюу Толгой төслийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа говийн болон газрын гүний усны талаарх мэдээллийг, МХЕГ-аас “Оюу Толгой” ХХК-д 2017.05.31-ний өдөр Байгаль орчны хяналтын чиглэлээр хийгдсэн ажлын дүнгийн талаарх мэдээллийг тус тус сонссон.
- 2021.10.08-13-ны өдрүүдэд ажлын дэд хэсгийн гишүүд Өмнөговь аймагт Оюу Толгой төслийн хүрээнд гүний уурхайд ашиглагдаж байгаа ус, усны байгаль орчинд нөлөөлж байгаа нөхцөл байдлын талаарх үйл ажиллагаатай танилцаж ажиллав.



ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ХЭСЭГ


2021 оны 8-10 дугаар сарын байдлаар хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцах, хянан шалгах үүрэг бүхий нийт 20 ажлын хэсэг (давхардсан тоогоор Улсын Их Хурлын 104 гишүүн ажилласан) байна.

Үүнээс:

- УИХ-ын даргын захирамжаар байгуулагдсан 5;
- Байнгын хорооны тогтоолоор байгуулагдсан 11;
- Дэд хорооны тогтоолоор байгуулагдсан 1;
- Байгууллагын үйл ажиллагаатай танилцах 3 ажлын хэсэг байна.

График 1. Хяналт шалгалтын чиглэлээр байгуулагдсан нийт ажлын хэсгийн статистик мэдээ /байгуулагдсан хугацаагаар/

- 2020 оны намрын ээлжит чуулганы хугацаанд байгуулагдсан (6)
- 2020 оны намрын чуулганы завсарлагааны хугацаанд байгуулагдсан (2)
- 2021 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд байгуулагдсан (11)
- 2021 оны намрын ээлжит чуулганы хугацаанд байгуулагдсан (1)



Хүснэгт 2. Хяналт шалгалтын чиглэлээр байгуулагдсан нийт ажлын хэсгийн статистик мэдээ /тогтоол, захирамж, шийдвэрийн төрлөөр/

Хугацаа	УИХ-ын даргын захирамж	Байнгын хорооны тогтоол	Дэд хорооны тогтоол	Байгууллагын үйл ажиллагаатай танилцах
2020 оны намрын ээлжит чуулганы хугацаанд байгуулагдсан	-	5	1	-
2020 оны намрын ээлжит чуулганы завсарлагааны хугацаанд байгуулагдсан	2	-	-	-
2021 оны хаврын ээлжит чуулганы болон завсарлагааны хугацаанд байгуулагдсан	3	5	-	3
2021 оны намрын ээлжит чуулганы хугацаанд байгуулагдсан	-	1	-	-
Үүнээс: Үйл ажиллагаа дуусгавар болсон	-	2	-	3
Нийт - 20	5	11	1	3



2.1. УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГЫН ЗАХИРАМЖААР БАЙГУУЛАГДСАН НИЙТ АЖЛЫН ХЭСЭГ

Хүснэгт 3. Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг

Д/д	Ажлын хэсэг байгуулсан захирамж	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн
1.	2021.03.02 №16 ЗАХИРАМЖ Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хүрээнд Дархлаажуулалтын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, хамтран ажиллах чиг үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Ж.Чинбүрэн Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Б.Баттөмөр, Б.Жаргалмаа, С.Одонтуяа, М.Оюунчимэг, Ж.Сүхбаатар ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Зөвлөх С.Эрдэнэчимэг, референт Х.Хэрлэн
2.	2021.03.11 №18 ЗАХИРАМЖ Концессын тухай хууль тогтоомж, гэрээний хэрэгжилтийг Дарханы төмөрлөгийн үйлдвэрт хэрхэн хэрэгжүүлж байгааг шалгах, санал, дүгнэлт гарган, шийдвэрийн төсөл боловсруулж Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Г.Дамдинням Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Б.Баттөмөр, Х.Болорчулуун, Х.Ганхуяг, Д.Өнөрболор, Г.Тэмүүлэн, Ч.Ундрам, О.Цогтгэрэл ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Ахлах зөвлөх Б.Батдэлгэр, референт Д.Гэрэлт-Од
3.	2021.03.18 №21 ЗАХИРАМЖ Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор газар эзэмших, ашиглахтай холбоотой газрын харилцааг зохицуулсан хууль тогтоомж болон Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Ж.Мөнхбат Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Ш.Адъяаа, П.Анужин, Б.Бат-Эрдэнэ, Б.Жаргалмаа ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Зөвлөх С.Эрдэнэчимэг, референт К.Пүрэвсүрэн
4.	2021.04.08 №28 ЗАХИРАМЖ Хууль хяналтын байгууллагад хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрхэн хэрэгжүүлж буйд болон хэвлэл мэдээллийн орчинд тархсан гэмт хэргийн шинжтэй мэдээллүүд нь улс орны дотоод аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх эсэхийг судлан санал, дүгнэлт гаргах, хууль тогтоомжийн төсөл боловсруулж, танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Б.Энх-Амгалан Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Б.Баярсайхан, Г.Дамдинням, Ц.Сандаг-Очир, Ч.Ундрам ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Ахлах зөвлөх Ч.Онончимэг
5.	2021.05.10 №33 ЗАХИРАМЖ Улс төрийн нөхцөл байдалтай холбогдуулан Улсын Их Хурлаас баталсан холбогдох хууль тогтоомжийн биелэлтийг шалгаж санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Ц.Мөнх-Оргил Ажлын хэсгийн дэд ахлагч: УИХ-ын гишүүн Н.Ганибал Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Ж.Батсуурь, Ц.Мөнхцэцэг, Ц.Сандаг-Очир, Ц.Туваан ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Ахлах зөвлөх Ч.Онончимэг

Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсгээс 2021 оны 8-10 дугаар сард ажилласан ажлын хэсгийн мэдээлэл



1. Улсын Их Хурлын даргын 2021 оны 16 дугаар захирамжаар байгуулагдсан “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хүрээнд Дархлаажуулалтын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, хамтран ажиллах чиг үүрэг бүхий ажлын хэсэг” ЭМЯ, ХӨСҮТ-өөс дархлаажуулалтын талаарх мэдээллийг өдөр тутам цахимаар хүлээн авч байна. Мөн Коронавируст халдвар /КОВИД-19/-ын эсрэг дархлал сэргээх нэмэлт тунгийн талаар судалсан байдал болон Монгол Улсад хийгдсэн судалгааны талаарх мэдээллийг цахимаар ажлын хэсгийн гишүүдэд хүргүүлсэн.

2. Улсын Их Хурлын даргын 2021 оны 28 дугаар захирамжаар байгуулагдсан “Хууль хяналтын байгууллагад хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрхэн хэрэгжүүлж буйд болон хэвлэл мэдээллийн орчинд тархсан гэмт хэргийн шинжтэй мэдээллүүд нь улс орны дотоод аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх эсэхийг судлан санал, дүгнэлт гаргах, хууль тогтоомжийн төсөл боловсруулж, танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг”-ийн боловсруулсан танилцуулга, дүгнэлтийг 10 дугаар сарын 26-ны өдөр ажлын хэсгийн ахлагчид танилцуулахаар хүргүүлсэн.

2.2. БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛООР БАЙГУУЛАГДСАН НИЙТ АЖЛЫН ХЭСЭГ

Хүснэгт 4. Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоолоор байгуулагдсан ажлын хэсэг

Д/д	Ажлын хэсэг байгуулсан тогтоол	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн
Төсвийн байнгын хороо		
1	2020.11.04 №05 ТОГТООЛ Монгол Улсын сүүлийн 15 жилийн төсвийн бодлого, төсвийн тэнцэлд дүн шинжилгээ хийж, цаашид баримтлах төсвийн бодлогын талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Х.Булгантуяа Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Н.Алтанхуяг, Г.Амартүвшин, Х.Баделхан, Ж.Батсуурь, Г.Тэмүүлэн, Б.Чойжилсүрэн ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: ТХШХ-ийн ажилтнууд
2	2020.12.30 №07 ТОГТООЛ Төсвийн хууль тогтоомжийн хэрэгжилт, "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай" УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 5.1.3, 8.3.15 дахь дэд заалтын биелэлтэд хяналт тавих зорилгоор төсвийн ерөнхийлөн захирагч болон хууль тогтоомжийн дагуу төсөвт орлого төвлөрүүлэх үүрэг хүлээдэг төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн 2019-2020 оны үйл ажиллагааг хамруулан шалгаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн С.Ганбаатар Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн С.Амарсайхан, Ц.Анандбазар, Ж.Батжаргал, Г.Тэмүүлэн ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Зөвлөх М.Солонго, референт Д.Гэрэлт-Од
3	2021.01.20 №01 ТОГТООЛ Монгол Улсын Их Хурлын 2020 оны 39 дүгээр тогтоолын (Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай) хэрэгжилтийг хангуулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Г.Тэмүүлэн Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Ц.Анандбазар, Х.Булгантуяа, С.Ганбаатар, Л.Мөнхбаатар, М.Оюунчимэг, Б.Пүрэвдорж ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Зөвлөх М.Солонго, референт Д.Гэрэлт-Од
Хууль зүйн байнгын хороо		
4	2020.12.24 №09 ТОГТООЛ Монгол Улс олон талт олон улсын гэрээнд нэгдэн орсноор хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайланг холбогдох олон улсын байгууллагад хүргүүлэх, тайлантай холбогдуулан олон улсын байгууллагаас ирүүлсэн зөвлөмжийн дагуу хэрэгжүүлж байгаа ажлын явц байдалтай танилцах, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Ц.Мөнх-Оргил Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн С.Амарсайхан, С.Бямбацогт, Б.Пүрэвдорж, Ц.Сэргэлэн ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Зөвлөх С.Эрдэнэчимэг, референт Д.Отгонбаатар
5	2021.03.15 №07 ТОГТООЛ Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр баталсан Монгол Улсын шүүхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн хэрэгжилтийг хангах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Ж.Сүхбаатар Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Ц.Мөнх-Оргил, Г.Мөнхцэцэг, Б.Пүрэвдорж, Ц.Сандаг-Очир ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Ахлах зөвлөх Ч.Онончимэг
6	2021.03.15 №08 ТОГТООЛ Гүйцэтгэх ажлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах явцад хүний үндсэн эрх, эрх чөлөө зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хяналт тавих, хариуцлага тооцох чиглэлээр хэрхэн ажиллаж байгаад үнэлгээ хийж, санал, дүгнэлт гаргах, холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох тухай хууль тогтоомжийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Б.Энхбаяр Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Н.Алтанхуяг, С.Бямбацогт, Д.Ганбат, Б.Энх-Амгалан ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Ахлах зөвлөх Ч.Онончимэг
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо		
7	2021.01.13 №01 ТОГТООЛ Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 39 дүгээр тогтоолын 1.5 дахь дэд заалт "төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих ажлын санхүүжилтийг "Эрдэнэт" ТӨҮГ-аар нийгмийн хариуцлагын хүрээнд шийдвэрлүүлэн 2021-2022 онд багтаан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах" гэж заасны хэрэгжилтийг хангах санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Б.Баярсайхан Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн П.Анужин, Ё.Баатарбилэг, Б.Жаргалмаа, Г.Мөнхцэцэг, Д.Өнөрболор, Ч.Ундрэм, Т.Энхтүвшин ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Зөвлөх С.Эрдэнэчимэг, референт К.Пүрэвсүрэн

ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ХЭСЭГ

Д/д	Ажлын хэсэг байгуулсан тогтоол	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын болон Төсвийн байнгын хорооны хамтарсан		
8	2021.05.25 №03 ТОГТООЛ "Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын 2021 онд төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны явц байдалтай танилцан, шалгаж, санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах" үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Х.Ганхуяг Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн А.Адьяасүрэн, Г.Амартүвшин, П.Анужин, Г.Мөнхцэцэг, Г.Энхтүвшин ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Референт С.Төрмөнх
Эдийн засгийн байнгын хороо		
9	2021.10.27 №13 ТОГТООЛ "Дархан-Улаанбаатар хот хоорондын автозам барих, ажлын явцыг эрчимжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, тодорхой асуудлаар үүрэг, чиглэл өгөх" үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Г.Дамдинням Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Ж.Батжаргал, Д.Батлут, Б.Баттөмөр, Ч.Ундрэм ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Зөвлөх С.Эрдэнэчимэг, ахлах референт Ш.Батцэнгэл, референт Д.Отгонбаатар

Хүснэгт 5. Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоолоор байгуулагдаж, үйл ажиллагаа дуусгавар болсон ажлын хэсэг

Нийгмийн бодлогын байнгын хороо		
1	2021.07.08 №03 ТОГТООЛ "Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай, Эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаатай танилцах" үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Д.Батлут Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн П.Анужин, Б.Бейсен, М.Оюунчимэг, Д.Өнөрболор, Ц.Сандаг-Очир, Ц.Туваан, Ж.Чинбүрэн, С.Чинзориг ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Зөвлөх С.Эрдэнэчимэг, референт К.Пүрэвсүрэн, Д.Отгонбаатар
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо		
2	2021.04.27 №02 ТОГТООЛ "Монгол Улсын Их хурлаас 2017 оны 7 дугаар сарын 06-ны өдөр баталсан Биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж, санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах" үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Ц.Мөнхцэцэг Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Г.Амартүвшин, Ё.Баатарбилэг, Б.Жаргалмаа, Ч.Ундрэм, Ж.Чинбүрэн, Т.Энхтүвшин ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Зөвлөх С.Эрдэнэчимэг, референт Ц.Рэнцэнтогтох

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.7 дахь заалт

Байнгын хорооны тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгээс 2021 оны 8-10 дугаар сард ажилласан 5 ажлын хэсгийн 2 нь үйл ажиллагаагаа дуусгавар болгосон байна.

Ажлын хэсгүүдийн үйл ажиллагаа:

2.2.1. Үйл ажиллагаа үргэлжилсэн ажлын хэсэг

1. Хууль зүйн байнгын хорооны 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 09 дүгээр тогтоолоор байгуулагдсан "Монгол Улс олон талт олон улсын гэрээнд нэгдэн орсноор хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайланг холбогдох олон улсын байгууллагад хүргүүлэх, тайлантай холбогдуулан олон улсын байгууллагаас ирүүлсэн зөвлөмжийн дагуу хэрэгжүүлж байгаа ажлын явц байдалтай танилцах, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг"-ийн үйл ажиллагаа:

- 2021.10.04-ний өдрийн ажлын хэсгийн хуралдаанд 2017 оны 193 дугаар тогтоолын дагуу олон улсын гэрээ, конвенцид харьцуулсан судалгаа хийсэн талаар танилцуулсан.
- Байнгын хорооны хуралдаанд танилцуулах ажлын хэсгийн явцын танилцуулгад "гэрээгээр хүлээсэн үүрэг, хууль тогтоомжид туссан байдал, тайлангийн мөрөөр өгсөн зөвлөмж болон хэрэгжилтийн талаар" тусгахыг ажлын дэд хэсгийн гишүүдэд үүрэг болгов.

- 2021.10.06-ны өдрийн Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд ажлын хэсгийн явцын талаар ажлын хэсгийн ахлагч танилцуулсантай холбогдуулан олон талт олон улсын гэрээ, конвенциор хүлээсэн үүрэг, хэрэгжилтийн тайлан, зөвлөмжийн биелэлтийг Хууль зүйн байнгын хорооноос гадна холбогдох бусад Байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд хамаарах олон улсын гэрээ, конвенцийн хэрэгжилтийн талаар хэлэлцэх нь зүйтэй гэж үзэж, зохих бэлтгэл хангах үүргийг ажлын хэсэгт өгсөн.



2. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны 2021 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор байгуулагдсан “Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 39 дүгээр тогтоолын 1.5 дахь дэд заалт “төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих ажлын санхүүжилтийг “Эрдэнэт” ТӨҮГ-аар нийгмийн хариуцлагын хүрээнд шийдвэрлүүлэн 2021-2022 онд багтаан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах” гэж заасны хэрэгжилтийг хангах санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг”-ийн үйл ажиллагаа:

- 2021.08.09-ний өдрийн ажлын хэсгийн хуралдаанаар үйл ажиллагааны явцын мэдээллийг сонсож, хэрэгжилт хангалтгүй байгаа асуудалд шуурхай арга хэмжээ авч ажиллахыг ажлын дэд хэсэгт үүрэг болгов.
- 2021.10.01-ний өдрийн ажлын хэсгийн хуралдаанд хийсэн ажлын дэд хэсгийн танилцуулгатай холбогдуулан орон нутагт ариун цэврийн байгууламжийн угсралтын үйл ажиллагаатай газар дээр нь танилцахаар тогтсон.
- 2021.10.23-24-ний өдрүүдэд ажлын хэсгийн гишүүд Дундговь аймгийн Дэлгэрхангай, Эрдэнэдалай, Гурвансайхан, Сайнцагаан сумдад ажиллаж, ариун цэврийн байгууламжийн гүйцэтгэлийн ажлын явц байдалтай танилцсан.

3. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо, Төсвийн байнгын хорооны 2021 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 06/03 дугаар тогтоолоор байгуулагдсан “Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын 2021 онд төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны явц байдалтай танилцан, шалгаж, санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг”-ийн үйл ажиллагаа:

• **Ажлын хэсгийн гишүүд:**

- 2021.08.05, 10-ны өдрүүдэд Нийслэлийн худалдан авах ажиллагааны болон Төрийн худалдан авах ажиллагааны газрын үйл ажиллагаа, цаашдын зорилттой;
- 2021.08.06, 09-ний өдрүүдэд Нийслэлийн Сонгинохайрхан, Баянгол, Хан-Уул дүүрэгт баригдаж буй 280 хүүхдийн цэцэрлэг, бага сургуулийн цогцолборын барилгын явцтай;
- 2021.08.10-ны өдөр Чингэлтэй дүүргийн 5 дугаар сургууль, Баянзүрх дүүргийн 26-р, Баянгол дүүргийн 5, 6 хороонд тус тус баригдаж буй сургуулийн болон Улсын төв номын сангийн, Их эзэн Чингис хааны музейн, Сүхбаатар дүүргийн Спортын хорооны барилгын явцтай;
- 2021.08.18-ны өдөр АШУИС-ийн Монгол-Японы эмнэлгийн үйл ажиллагаа, төсвийн хөрөнгө оруулалтын байдалтай тус тус танилцаж ажилласан.



- 2021.08.12-ны өдөр “Барилгын материалын үнийн өсөлтийн шалтгаан ба шийдэл” сэдвээр Барилга хот байгуулалтын яаман дээр, “Барилгын материалын үнийн өсөлтийн шалтгаан, Коронавируст халдварын нөлөө” сэдвээр Сангийн яаман дээр тус тус цахим хэлэлцүүлэг хийсэн.
- 2021.08.18, 19-ний өдрүүдэд арматур үйлдвэрлэгчид, барилгын хөөсөнцөр үйлдвэрлэгчид, цемент, бетон зуурмаг үйлдвэрлэгчидтэй тус тус цахим уулзалт зохион байгуулж, өнөөгийн байдал, цаашдын зорилтын талаар санал солилцсон.
- 2021.10.04-ний өдрийн ажлын хэсгийн хуралдаанаар ажлын хэсгийн тайланг хэлэлцсэн.
- 2021.10.19-ний өдрийн БСШУСБХ, ТБХ-ны хамтарсан хуралдаанд ажлын хэсгийн тайлан болон ажлын хэсгийн санал, дүгнэлтэд үндэслэн боловсруулсан Засгийн газарт чиглэл өгөх тухай Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулсан. Байнгын хороодын гишүүдээс тогтоолын төслийг дахин боловсруулах санал гаргаснаар хуралдааныг түр хойшлуулсан.

2.2.2. Үйл ажиллагаа дуусгавар болсон ажлын хэсэг



1. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны 2021 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 02 дугаар тогтоолоор байгуулагдсан “Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 7 дугаар сарын 06-ны өдөр баталсан Биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилт, салбарын хөрөнгө оруулалт, санхүүжилтийн талаар шалгаж санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг”-ийн үйл ажиллагаа:

- 2021.09.24-ний өдрийн ажлын хэсгийн хуралдаанаар Үндэсний шигшээ баг, спортын холбоодын үйл ажиллагааны болон Спортын шинжлэх ухааны хөгжлийн, Нийтийн биеийн тамирын хөгжлийн талаар холбогдох газрын танилцуулга, мэдээллийг сонссон. Мэдээлэлтэй холбогдуулан ажлын хэсгийн гишүүд 2021.09.30-ны өдөр “Техник спортын төв”-ийн үйл ажиллагаатай танилцсан.
- 2021.10.04-ний өдрийн Байнгын хорооны хуралдаанд ажлын хэсгийн тайлан болон Засгийн газарт чиглэл өгөх тухай тогтоолын төслийг танилцуулсан. **БСШУСБХ-ны 2021.10.19-ний өдрийн 08 дугаар тогтоолоор Засгийн газарт чиглэл өгч, ажлын хэсгийн үйл ажиллагаа дуусгавар болсон.**

2. Нийгмийн бодлогын байнгын хорооны 2021 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн 03 дугаар тогтоолоор байгуулагдсан “Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай, Эрүүл мэндийн тухай хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгах, Эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаатай танилцах үүрэг бүхий ажлын хэсэг”-ийн үйл ажиллагаа:

Ажлын хэсгийн гишүүдээс гаргасан саналын дагуу дараах хуваариар эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаатай танилцаж ажилласан. Үүнд:

- 2021.08.19-20-ны өдрүүдэд УИХ-ын гишүүн С.Чинзориг Өвөрхангай аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Хархорин сумын эмнэлгийн үйл ажиллагаатай танилцсан;
- 2021.08.29-ний өдөр УИХ-ын гишүүн, ажлын хэсгийн гишүүн Ц.Сандаг-Очироор ахлуулсан ажлын хэсэг Төв аймгийн Зуунмод, Эрдэнэ сум, Нийслэлийн Багануур дүүрэгт ажиллаж, эрүүл мэндийн байгууллагуудын удирдлагуудтай уулзаж, үйл ажиллагаатай танилцсан;
- 2021.09.27-ны өдөр УИХ-ын гишүүн, ажлын хэсгийн гишүүн Ж.Чинбүрэнгээр ахлуулсан ажлын хэсэг Сүхбаатар аймгийн Баруун-Урт, Асгат, Дарьганга сумдад ажилласан;
- 2021.10.11-ний өдөр Улсын 2-р төв эмнэлэг, Сүхбаатар дүүргийн нэгдсэн эмнэлэгт ажилласан;
- 2021.10.12-ны өдөр Монголын эрүүл мэндийн байгууллагын ҮЭ-ийн холбооны төлөөлөлтэй уулзсан. Эрүүл мэндийн яаманд ажиллаж, яамны үйл ажиллагаатай танилцаж, эрүүл мэндийн байгууллагын удирдлагуудтай уулзалт хийсэн;
- 2021.10.13, 15-ны өдрийн ажлын хэсгийн хуралдаанаар Эрүүл мэндийн яам, Сангийн яамны ажилтнуудтай уулзаж, анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын гүйцэтгэлийн санхүүжилтийн асуудлаар санал солилцсон.
- 2021.10.18-ны өдөр Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын удирдлагуудтай уулзаж, үйл ажиллагааны талаар тус тус санал солилцсон.

2021.10.19-ний өдрийн Байнгын хорооны хуралдаанд ажлын хэсгийн тайлан болон Засгийн газарт чиглэл өгөх тогтоолын төслийг танилцуулсан. **НББХ-ны 2021.10.19-ний өдрийн 05, 2021.10.26-ны өдрийн 06 дугаар тогтоолоор тус тус Засгийн газарт чиглэл өгч, ажлын хэсгийн үйл ажиллагаа дуусгавар болсон.**

2.3. БАЙНГЫН ХОРООНЫ ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНД БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ТАНИЛЦАХ**Хүснэгт 6. Байгууллагын үйл ажиллагаатай танилцах**

Д/д	Танилцсан байгууллагын нэр	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн
Инноваци, цахим бодлогын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд		
1.	2021.08.03 - Тагнуулын ерөнхий газар; - "Үндэсний дата төв" УТӨГ	Байнгын хорооны дарга: УИХ-ын гишүүн Н.Учрал Гишүүд: УИХ-ын гишүүн П.Анужин, Э.Бат-Амгалан, Т.Доржханд, Б.Саранчимэг, Ж.Сүхбаатар, Д.Цогтбаатар
2.	2021.08.05 - Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар; - Улсын бүртгэлийн ерөнхий газар	Байнгын хорооны дарга: УИХ-ын гишүүн Н.Учрал Гишүүд: УИХ-ын гишүүн Э.Бат-Амгалан, Б.Саранчимэг, Ж.Сүхбаатар, Д.Цогтбаатар
3.	2021.08.12 Монголбанк	Байнгын хорооны дарга: УИХ-ын гишүүн Н.Учрал Гишүүд: УИХ-ын гишүүн Г.Амартүвшин, Х.Булгантуяа, Б.Энхбаяр

2021 оны 8-10 дугаар сард Улсын Их Хурлын гишүүдээс Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын дарга нарт тавьсан 5 асуулга, 10 асуултын хариуг ирүүлж, 4 асуулга, 12 асуулт тавьсан байна.

3.1. АСУУЛГА



- 2021.08.30-ны өдөр УИХ-ын гишүүн С.Одонтуяагаас Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэнд хандаж “Төв банк /Монголбанк/-ны тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар” тавьсан 31 дүгээр асуулга;

<http://parliament.mn/n/eyayn>



- 2021.09.13-ны өдөр УИХ-ын гишүүн Б.Энх-Амгалангаас Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Уртнасанд хандаж “Говь-Алтай аймгийн Тахийн тал дахь Говийн их дархан цаазат газрын “Б” хэсгийн хамгаалалтын захиргааг нүүлгэн шилжүүлсэнтэй холбоотой асуудлын талаар” тавьсан 33 дугаар асуулга;

<http://parliament.mn/n/8eayn>



- 2021.10.01-ний өдөр УИХ-ын гишүүн Т.Доржхандаас Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд хандан “Шатахууны хомсдолтой холбоотой авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар” тавьсан 36 дугаар асуулга;

<http://parliament.mn/n/bcayn>



- 2021.10.04-ний өдөр УИХ-ын гишүүн Т.Доржхандаас Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд хандаж “Сайжруулсан шахмал түлшний хомсдол үүссэн шалтгаан, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар” тавьсан 37 дугаар асуулга.

<http://parliament.mn/n/boayn>

3.2. АСУУЛГЫН ХАРИУ

- 2021.07.29-ний өдөр УИХ-ын гишүүн Н.Ганибалаас Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд хандан “Нийгмийн хамгааллын чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа зарим арга хэмжээний талаар” тавьсан 25 дугаар асуулгын хариуг ЗГХЭГ-ын 2021.08.27-ны өдрийн ХЭГ/2133 дугаар албан бичгээр;



- 2021.08.30-ны өдөр УИХ-ын гишүүн С.Одонтуяагаас Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэнд хандаж “Төв банк /Монголбанк/-ны тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар” тавьсан 31 дүгээр асуулгын хариуг 2021.09.27-ны өдрийн А-1/963 дугаар албан бичгээр;

<http://parliament.mn/n/erayn>



- 2021.09.13-ны өдөр УИХ-ын гишүүн Б.Энх-Амгалангаас Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Уртнасанд хандаж “Говь-Алтай аймгийн Тахийн тал дахь Говийн их дархан цаазат газрын “Б” хэсгийн хамгаалалтын захиргааг нүүлгэн шилжүүлсэн талаар” тавьсан 33 дугаар асуулгын хариуг ЗГХЭГ-ын 2021.10.01-ний өдрийн 01/4593 дугаар албан бичгээр;

<http://parliament.mn/n/8cayn>



- 2021.10.01-ний өдөр УИХ-ын гишүүн Т.Доржхандаас Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд хандан “Шатахууны хомсдолтой холбоотой авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар” тавьсан 36 дугаар асуулгын хариуг 2021.10.26-ны өдрийн ХЭГ/2538 дугаар албан бичгээр;

<http://parliament.mn/n/5aayn>



- 2021.10.04-ний өдөр УИХ-ын гишүүн Т.Доржхандаас Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд хандан “Сайжруулсан шахмал түлшний хомсдол үүссэн шалтгаан, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар” тавьсан 37 дугаар асуулгын хариуг 2021.10.26-ны өдрийн ХЭГ/2537 дугаар албан бичгээр тус тус ирүүлсэн.

<http://parliament.mn/n/5hayn>

3.3. АСУУЛГЫН ХАРИУГ ХЭЛЭЛЦСЭН МЭДЭЭЛЭЛ

2021.10.08-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар УИХ-ын гишүүн Д.Ганбатаас Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд хандаж “Нүүрс тээвэрлэлтийн салбарт хэрэгжиж буй тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн байдал, цаашид Засгийн газраас авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар” тавьсан 16 дугаар асуулгын хариуг хэлэлцсэн.

3.4. АСУУЛТ



- 2021.08.03-ны өдөр УИХ-ын гишүүн Н.Ганибалаас Сангийн сайд Б.Жавхланд хандаж “Ойн тухай хууль тогтоомжийн зөрчлийн талаар мэдээлэл өгсөн, зөрчлийг илрүүлсэн, илрүүлэхэд туслалцаа үзүүлсэн этгээдэд урамшуулал олгох журмын хэрэгжилтийн талаар” тавьсан 26 дугаар асуулт;

<http://parliament.mn/n/oazon>

- 2021.08.03-ны өдөр УИХ-ын гишүүн Н.Ганибалаас Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Уртнасанд хандаж “Ойн тухай хууль тогтоомжийн зөрчлийн талаар мэдээлэл өгсөн, зөрчлийг илрүүлсэн, илрүүлэхэд туслалцаа үзүүлсэн этгээдэд урамшуулал олгох журмын хэрэгжилтийн талаар” тавьсан 27 дугаар асуулт;



- 2021.08.04-ний өдөр УИХ-ын гишүүн Н.Ганибалаас Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайханд хандаж “Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан суманд үйл ажиллагаа явуулдаг “Монгол ураниум ресурс” ХХК нь Усны тухай хууль тогтоомжийг хэрхэн дагаж мөрдөж байгаа талаар” тавьсан 28 дугаар асуулт;

<http://parliament.mn/n/tyzon>

- 2021.08.12-ны өдөр УИХ-ын гишүүн Н.Ганибалаас Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Уртнасанд хандаж “Хог хаягдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн явцын талаар” тавьсан 29 дүгээр асуулт;



- 2021.08.13-ны өдөр УИХ-ын гишүүн Г.Тэмүүлэнгээс Шадар сайд С.Амарсайханд хандаж “Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай” хуулийн хэрэгжилт, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр”-ийн бүтээн байгуулалтын ажлын явцын талаар” тавьсан 30 дугаар асуулт;

<http://parliament.mn/n/yaayn>

- 2021.09.06-ны өдөр УИХ-ын гишүүн Ч.Ундрамаас Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгаланд хандан “2021 оны элсэлтийн ерөнхий шалгалтын талаарх хууль тогтоомжийн хэрэгжилт, шалгалт зохион байгуулалтын талаар” тавьсан 32 дугаар асуулт;



- 2021.09.21-ний өдөр УИХ-ын гишүүн Д.Өнөрболороос Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд хандан “Бензин, шатахууны хомсдол үүсээд байгаа өнөөгийн нөхцөл байдал, цаашид авах арга хэмжээний талаар” тавьсан 34 дүгээр асуулт;

<http://parliament.mn/n/4ozon>

- 2021.09.25-ны өдөр УИХ-ын гишүүн Д.Өнөрболороос Эрүүл мэндийн сайд С.Энхболдод хандаж “Коронавируст халдварын цар тахлын үед авч хэрэгжүүлж буй арга хэмжээ болон хүндрэл үүсвэл асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар” тавьсан 35 дугаар асуулт;



- 2021.10.04-ний өдөр УИХ-ын гишүүн Ц.Мөнхцэцэгээс Эрчим хүчний сайд Н.Тавинбэхэд хандаж “Сайжруулсан шахмал түлшний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх талаар” тавьсан 38 дугаар асуулт;

<http://parliament.mn/n/dcaayn>

- 2021.10.14-ний өдөр УИХ-ын гишүүн М.Оюунчимэгээс Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтарт хандан ““МИАТ” төрийн өмчит хувьцаат компанийн үйл ажиллагааны талаар” тавьсан 39 дүгээр асуулт;



- 2021.10.26-ны өдөр УИХ-ын гишүүн Ч.Ундрамаас Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайханд хандаж “Улаан буудайн үнийг тогтоож буй үндэслэл болон тариаланчдад олгосон зээлийн эргэн төлөлтийг хойшлуулах талаар” тавьсан 40 дүгээр асуулт;

<http://parliament.mn/n/ueayn>

- 2021.10.26-ны өдөр УИХ-ын гишүүн О.Цогтгэрэлээс Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд хандаж “Эрдэнэбүрэнгийн Усан Цахилгаан Станц төслийн байршил, нэрийг өөрчлөх боломж байгаа эсэх, уг төслийн байгаль орчин, айл өрхөд нөлөөлөх байдлын үнэлгээг хэрхэн тооцсон талаар” тавьсан 41 дүгээр асуулт.

3.5. АСУУЛТЫН ХАРИУ

- 2021.08.03-ны өдөр УИХ-ын гишүүн Н.Ганибалаас Сангийн сайд Б.Жавхланд хандаж “Ойн тухай хууль тогтоомжийн зөрчлийн талаар мэдээлэл өгсөн, зөрчлийг илрүүлсэн, илрүүлэхэд туслалцаа үзүүлсэн этгээдэд урамшуулал олгох журмын хэрэгжилтийн талаар” тавьсан 26 дугаар асуултын хариуг 2021.08.27-ны өдрийн 4-2/4903 дугаар албан бичгээр;
- 2021.08.03-ны өдөр УИХ-ын гишүүн Н.Ганибалаас Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Уртнасанд хандаж “Ойн тухай хууль тогтоомжийн зөрчлийн талаар мэдээлэл өгсөн, зөрчлийг илрүүлсэн, илрүүлэхэд туслалцаа үзүүлсэн этгээдэд урамшуулал олгох журмын хэрэгжилтийн талаар” тавьсан 27 дугаар асуултын хариуг 2021.08.17-ны өдрийн 01/3633 дугаар албан бичгээр;
- 2021.08.04-ний өдөр УИХ-ын гишүүн Н.Ганибалаас Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайханд хандаж “Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан суманд үйл ажиллагаа явуулдаг “Монгол ураниум ресурс” ХХК нь Усны тухай хууль тогтоомжийг хэрхэн дагаж мөрдөж байгаа талаар” тавьсан 28 дугаар асуултын хариуг 2021.08.26-ны өдрийн ЗГ-2/689 дугаар албан бичгээр;
- 2021.08.12-ны өдөр УИХ-ын гишүүн Н.Ганибалаас Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Уртнасанд хандаж “Хог хаягдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн явцын талаар” тавьсан 29 дүгээр асуултын хариуг 2021.08.17-ны өдрийн 01/3633 дугаар албан бичгээр;
- 2021.08.13-ны өдөр УИХ-ын гишүүн Г.Тэмүүлэнгээс Шадар сайд С.Амарсайханд хандаж “Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай” хуулийн хэрэгжилт, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр”-ийн бүтээн байгуулалтын ажлын явцын талаар” тавьсан 30 дугаар асуултын хариуг 2021.08.17-ны өдрийн ЗГ-2/684 дугаар албан бичгээр;



<http://parliament.mn/n/yhayn>



- 2021.09.21-ний өдөр УИХ-ын гишүүн Д.Өнөрболороос Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд хандаж “Бензин, шатахууны хомсдол үүсээд байгаа өнөөгийн нөхцөл байдал, цаашид авах арга хэмжээний талаар” тавьсан 34 дүгээр асуултын хариуг 2021.10.06-ны өдрийн 01/2415 дугаар албан бичгээр;

<http://parliament.mn/n/8aayn>

- 2021.09.25-ны өдөр УИХ-ын гишүүн Д.Өнөрболороос Эрүүл мэндийн сайд С.Энхболдод хандаж “Коронавируст халдварын цар тахлын үед авч хэрэгжүүлж буй арга хэмжээ болон хүндрэл үүсвэл асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар” тавьсан 35 дугаар асуултын хариуг 2021.10.05-ны өдрийн 1а/5274 дугаар албан бичгээр;



- 2021.10.04-ний өдөр УИХ-ын гишүүн Ц.Мөнхцэцэгээс Эрчим хүчний сайд Н.Тавинбэхэд хандаж “Сайжруулсан шахмал түлшний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх талаар” тавьсан 38 дугаар асуултын хариуг 2021.10.13-ны өдрийн 1а/3647 дугаар албан бичгээр;

<http://parliament.mn/n/mwayn>


- 2021.10.14-ний өдөр УИХ-ын гишүүн М.Оюунчимэгээс Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтарт хандан ““МИАТ” төрийн өмчит хувьцаат компанийн үйл ажиллагааны талаар” тавьсан 39 дүгээр асуултын хариуг 2021.10.28-ны өдрийн 01/4833 дугаар албан бичгээр;
- 2021.10.26-ны өдөр УИХ-ын гишүүн Ч.Ундрамаас Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайханд хандаж “Улаан буудайн үнийг тогтоож буй үндэслэл болон тариаланчдад олгосон зээлийн эргэн төлөлтийг хойшлуулах талаар” тавьсан 40 дүгээр асуултын хариуг 2021.09.17-ны өдрийн 1А/4786 дугаар албан бичгээр тус тус ирүүлсэн.

3.5. АСУУЛТЫН ХАРИУГ ХЭЛЭЛЦСЭН МЭДЭЭЛЭЛ

Улсын Их Хурлын гишүүний хүсэлтийн дагуу Байнгын хорооны хуралдаанаар дараах 2 асуултын хариуг хэлэлцсэн. Үүнд:

- 2021.06.27-ны өдөр УИХ-ын гишүүн Г.Дамдиннямаас Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтарт хандан “Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.11 км авто замын чанар болон гүйцэтгэл, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хэрхэн хангаж ажиллаж байгаа талаар” тавьсан 23 дугаар асуултын хариуг 2021.10.20-ны өдрийн Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлсэн. Үүний үр дүнд Дархан-Улаанбаатар хот хоорондын авто зам барих ажлын явцыг эрчимжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсэг УИХ-ын Байнгын хорооны 2021 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 13 дугаар тогтоолоор байгуулагдсан.
- 2021.08.13-ны өдөр УИХ-ын гишүүн Г.Тэмүүлэнгээс Монгол Улсын Шадар сайд С.Амарсайханд хандаж “Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай” хуулийн хэрэгжилт, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр”-ийн бүтээн байгуулалтын ажлын явцын талаар” тавьсан 30 дугаар асуултын хариуг 2021.10.05-ны өдрийн Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлсэн. Үүний үр дүнд “Газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх талаар” УИХ-ын Байнгын хорооны 2021 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор Засгийн газарт үүрэг өгсөн.

Монгол Улсын Их Хурлын
чуулганы хуралдааны дэгийн тухай
хуулийн 109 дүгээр зүйл



4.1. ЕРӨНХИЙ САЙДЫН МЭДЭЭЛЭЛ

2021.10.15-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд “Намрын ургац хураалт болон хөдөө аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын талаар” Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан мэдээлэл хийв.

4.2. БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНААР СОНССОН МЭДЭЭЛЭЛ

Улсын Их Хурлаар хэлэлцэхээр хуульд тусгайлан заасан мэдээлэл, тайлан, илтгэл, танилцуулгыг эрх бүхий байгууллага хуульд заасан хугацаанд ирүүлэх үүрэгтэй бөгөөд холбогдох Байнгын хороо харьяаллын дагуу хэлэлцдэг. 2021 оны 8-10 дугаар сард Байнгын хорооны хуралдаанаар дараах 3 тайланг сонссон байна.

2021.10.06-ны өдрийн НБХ-ны хуралдаанаар:

- Коронавируст халдвар /Ковид-19/-ын лабораторийн оношилгоо, эмчилгээ, дархлаажуулалтын талаар

2021.10.19-ны өдрийн БСШУСБХ-ны хуралдаанаар:

- Цар тахлын үеийн боловсролын салбарын үйл ажиллагааны талаар

2021.10.20-ны өдрийн ЁЗСХБХ-ны хуралдаанаар:

- Төрийн албаны шинэтгэл, хэрэгжүүлэх арга замын талаар

ТАВ. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

5.1. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ



Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн явцын хяналт шинжилгээ

Боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооноос ирүүлсэн саналын дагуу Номын сангийн тухай хуулийн хэрэгжилтэд **явцын хяналт шинжилгээ** хийж, тайланг Ерөнхий нарийн бичгийн даргын 2021.10.18-ны өдрийн ТГ-01/1126 дугаар албан бичгээр Боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд хүргүүлсэн.

<http://parliament.mn/n/bhaon>

5.2. ҮР ДАГАВРЫН ҮНЭЛГЭЭ



Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ

Эдийн засгийн байнгын хорооноос ирүүлсэн саналын дагуу Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн хэрэгжилтийн **үр дагаврын үнэлгээ** хийж, холбогдох тайланг Ерөнхий нарийн бичгийн даргын 2021.09.30-ны өдрийн ТГ-01/1063 дугаар албан бичгээр Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлсэн;

<http://parliament.mn/n/byaon>



Нийгмийн бодлогын байнгын хорооноос ирүүлсэн саналын дагуу Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн хэрэгжилтийн **үр дагаврын үнэлгээ** хийж, холбогдох тайланг Ерөнхий нарийн бичгийн даргын 2021.09.30-ны өдрийн ТГ-01/1062 дугаар албан бичгээр Нийгмийн бодлогын байнгын хороонд хүргүүлсэн;

<http://parliament.mn/n/yaaon>



Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтоос ирүүлсэн хүсэлтийн дагуу Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийн **үр дагаврын үнэлгээ** хийж, холбогдох тайланг Ерөнхий нарийн бичгийн даргын 2021.10.18-ны өдрийн ТГ-01/1127 тоот албан бичгээр Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтод хүргүүлсэн.

<http://parliament.mn/n/7wayn>